



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЗҮҮНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/101

Жаргалант


Хоггүй цэвэр орчин аян зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.5, 9.5.1, 9.5.2, 9.5.3 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдал ихсэн, хаврын хуурайшилт эхэлж байгаатай холбогдуулаад “Хоггүй цэвэр орчин” аяныг 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай зохион байгуулсугай.
2. Хоггүй цэвэр орчин аян зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. Өөрийн байгууллагын эзэмшил, ашиглалтын газрын ойр орчмын 100 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэж, хогийн цэгт устгахыг иргэн, байгууллага, аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.
4. Эзэмшлийн ойн сангийн талбайн хог хаягдлыг цэвэрлэж, зориулалтын цэгээс бусад газарт хог хаяхгүй байх талаар сурталчилж байнгын хяналт тавьж ажиллахыг ойн сангийн нөхөрлөлийн эзэд нарт даалгасугай.
5. “Хоггүй цэвэр орчин” аяныг нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчилж, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал цэвэрлэх газрын байршлыг тогтоож хариуцуулан ажиллуулахыг багийн Засаг дарга /Ч.Уранчимэг, С.Бат-Эрдэнэ, Д.Чулуунбаатар / нарт үүрэг болгосугай.
6. Нийтийг хамарсан ажлаас зайлсхийсэн болон зориулалтын бус газарт хог хаясан иргэн, аж ахуйн нэгжийн дарга эрхлэгч нарт Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.2, 10.3.3, 10.3.5 20.4 дэх заалтыг үндэслэн хариуцлага тооцож ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч О.Эрдэнчимэг, Байгаль хамгаалагч М.Нямдорж нарт үүрэг болгосугай.
7. Зориулалтын бус газарт хог хаях, хаврын хуурайшилтын үед ил задгай хог шатаах, болгоомжгүйгээс ой хээрийн түймэр гаргах явдалд анхаарч ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.

ЗАСАГ ДАРГА

Х.БАДРАЛ



0000223

“ХОГГҮЙ ЦЭВЭР ОРЧИН” АЯН ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдлыг цэвэрлүүлэх, сумын төвд үүссэн хог хаягдлыг дарж устгах, нийтийг хамарсан хог цэвэрлэгээнд иргэд, байгууллагын идэвх санаачлагыг нэмэгдүүлэн оролцуулах ажлыг зохион байгуулж хоггүй сум болоход оршино.

№	Зохион байгуулах ажил	Хамрах хүрээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хог хаягдал ихээр төвлөрсөн цэгүүд, нийтийн эзэмшлийн талбайг зурагжуулан ажлын үр дүнгийн харьцуулалтаар иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулах	Сумын нутаг дэвсгэрт үүссэн хур хогийг цэвэрлүүлж устгах	2-р улиралд	Багийн засаг дарга нар
2	Жолооч нарт Хог хаягдлын талаар хууль эрх зүйн сургалтыг зохион байгуулж эрх, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх.	1,2,3-р багийн нутаг	2,3-р улиралд	БОХУБ, Байгаль хамгаалагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа, БЗД
3	Зориулалтын бус зөвшөөрөлгүй цэгт хог асгасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон ажиллах, мэдээлэл өгсөн хүнийг урамшуулах	1,2,3-р багийн нутаг	Жилдээ	БОХУБ, Байгаль хамгаалагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа, БЗД
4	Нийтийг хамарсан хог цэвэрлэгээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах	1,2,3-р баг	Жилдээ	БЗД, ААНБ-ын дарга нар
5	Бэлчээр, ойн сангийн талбайд хаясан хогийг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	Эзэмшлийн ойн сангийн газрууд	жилдээ	БОХУБ, Байгаль хамгаалагч

6	Орчны тохижилтыг сайжруулах, хог хаягдлыг цэвэрлэх хүрээнд хийгдсэн ажлын тайланг нэгтгэх.	1.2-р баг	Сар бүрийн 25-ны дотор	БЗД, Аж ахуйн нэгж байгууллагын дарга нар
7	Үхсэн мал амьтны сэг зэмийг устгах, ариутгах ажлыг зохион байгуулах.	Сумын хэмжээнд	2-р улиралд	ХАА-н тасаг МЭХУБ
8	Дэлгүүр үйлчилгээний газар, байгууллагын гадна хогийн савны тоог нэмэгдүүлэх ариутгал халдваргүйжилтийг тогтмол хийх.	1,2-р багийн нутаг	2-р улирал	Байгууллагын дарга, эрхлэгч
9	Газар эзэмшигч аж ахуйн нэгж байгууллага, иргэний газар эзэмших гэрээнд хог хаягдлын талаар тусгах. Хог хаягдлын төлбөр хураамжийг төвлөрүүлэхэд, хяналт тавих	Газар эзэмшигч иргэн, ААНБ	жилдээ	Газрын харилцааны мэргэжилтэн, БОХУБ, Татвар хураагч, БЗДарга нар.